



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/667

Зуунмод

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 65 дугаар зүйлийн 65.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 66 дугаар тогтоолын 9.6, Монгол Улсын Цэргийн нийтлэг дүрмүүдийн хоёрдугаар бүлэг Цэргийн алба хаагчид хүртээх сайшаал, түүнийг хэрэглэх журмын 11.1.4 дэх заалт, Батлан хамгаалахын сайд, Төв аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээний 2.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2022 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагаар цэргийн жинхэнэ албанд татагдан ирж, Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлд алба хааж байгаа шинэ дайчдын тангараг өргөх ёслолын ажиллагааг тохиолдуулан байлдагч нарыг цэргийн албаар бахархах, тэдний сэтгэл санааг дэмжих зорилгоор аймгийн Засаг даргын гарын бэлэг гардуулсугай.

2.Төв аймгаас хугацаат цэргийн албанд татагдсан хугацаат цэргийн алба хаагчдыг эргэх ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Цэргийн штабын дарга дэд хурандаа (Т.Төмөрчөдөрт)-д даалгасугай.

3.Цэргийн алба хаагч байлдагч нарын нэрийг нэгдүгээр, шагналын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


4.Дурсгалын зүйлд зарцуулагдах 1,000,000 (нэг сая) төгрөгийг хуваарилагдаагүй зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ю.Бямбацогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА




Д.МӨНХБААТАР


Аймгийн Засаг даргын 2022 оны
11 дүгээр сарын 18 -ны өдрийн
А/667 дугаар захирамжийн
хоёрдугаар хавсралт



ШАГНАЛЫН ТӨСӨВ

Д/д	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Гарын бэлэг	15	28,700	430,000
2	Төв аймгаас хугацаат цэргийн албанд татагдсан дайчдыг эргэх	57	10,000	570,000
Бүгд дүн				1.000.000

ТӨСӨВ ЗОХИОСОН:
ЦЭРГИЙН ШТАБЫН ДАРГА
ДЭД ХУРАНДАА  Т.ТӨМӨРЧӨДӨР

ХЯНАСАН:
САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН  Ч.ЦЭЦЭГСҮРЭН

___оОо___

